



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/438

Мөрөн сум

Түр зам гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.3.1, 9.5, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын 7-р багт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /УТ2403901081/ баригдах “Ахмад настны асрамж үйлчилгээний барилга”-ын ажил эхэлсэнтэй холбогдуулан тус багт байрлах ААН, айл өрх, 19,20 дугаар байрны иргэдийн аюулгүй байдлыг хангаж 2024 оны 11 дүгээр сарын 15 хүртэл түр зам гаргасугай.

2. 19,20 дугаар байрны зүүн хэсэгт орц гарцыг нээх, гурилын үйлдвэрийн урд хэсгийн төмөр хашааг авч зорчих хэсгийг чөлөөтэй болгож явган болон авто тээврийн хэрэгсэл зорчиход саадгүй болгох ажлыг зохион байгуулахыг Хөвсгөл аймгийн Замын цагдаагийн тасгийн дарга (Б.Батбаатар)-т үүрэг болгосугай.

3. Барилгын ажил эхлүүлэхэд түр хашааг норм дүрэм стандартын дагуу барихыг гүйцэтгэгч Уул өвгөд ХХК захирал (Б.Цогзолмаа)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар) -д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ